

Гадаад харилцааны яамны “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн 2024 оны III улирлын тайлан

Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 3.2.3.6¹, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.2², 8.5³-д заасныг тус тус үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагын “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн явц болон нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, цаг хугацаанд нь байршуулсан эсэхэд хяналт тавьж, үнэлгээ өгч, зөвлөмж хүргүүлэн эрсдэлийн удирдлагаар ханган ажиллав.

“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9⁴-д заасны дагуу шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай товч тайланг 2024 оны I болон II улирлын байдлаар Гадаад харилцааны яамны цахим хуудаст байршуулсан болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 55 (ГХЯ, Гадаад харилцааны сайдын багц, ДТГ-ын төвийн тооцоо, ДБҮЭГ, ЮНЕСКО, ДТГ 50) байгууллагын шилэн дансны III улирлын тайланг Сангийн яамны “Шилэн дансны нэгдсэн цахим хуудас”-т байршуулж, тайлагнасан байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв. Жакарта, Ташкент дахь ДТГ шинээр нээгдсэн тул ЭСЯ-ны хэрэглэгчийн эрхийг нэмж оруулах, нягтлан бодогч нарт шилэн дансны мэдээллийг хэрхэн оруулах, яаж ажиллах талаар СБХ-ээс зааварчилгаа өгч ажиллахыг зөвлөж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт III улирлын байдлаар **100.0** хувийн гүйцэтгэлтэй, мэдээллийг цаг хугацаанд нь байршуулсан чанарын үзүүлэлт **98.52** хувь буюу “**бүрэн хэрэгжсэн**” үнэлгээтэй байна.


“Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийн 2024 оны III улирлыг өмнөх улиралтай харьцуулбал хуулийн хугацаанд байршуулсан хэрэгжилтийн чанарын үзүүлэлт **0.18** хувиар өссөн үзүүлэлттэй байгааг доорх графикаар харуулав.

¹ шилэн дансны хөтлөлт.

² Дотоод аудитын алба нь улирлын нэгдсэн тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дараа сарын 25-ны дотор хүргүүлнэ.

³ Төсвийн ерөнхийлөн захирагч (дотоод аудитын алба) нь Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

⁴ Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл



Шилэн дансны цахим хуудаст төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагууд 2024 оны III улирлын байдлаар 12 төрлийн 7155 мэдээллийг байршуулахаас 7049 мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж байршуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудад “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах чиглэлээр 5 зөвлөмж өгч ажиллав.

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ